



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
202 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 46.15, 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дүрмийн 7.3, 7.4, 7.8.6, 7.8.7, 7.11 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол, тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хурлын зааланд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
 - 2.2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг батлах тухай;
 - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
 - 2.4. 2023 оны ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, үндэслэлийг танилцуулах тухай
 - 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
 - 2.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсвийг батлах тухай;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр байхаар тогтсугай.
4. 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс хоёроос доошгүй өдөр тутмын сонин, телевиз, компанийн болон Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, зарыг 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр анх нийтэд мэдээлсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 1 дүгээр хавсралтаар, танилцах баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, компанийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 0900-

1800 цагийн хооронд “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн төв байранд болон цахим хэлбэр /www.telecommongolia.mn/-ээр танилцах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Х.Цэцэгмаа/-д даалгасугай.

6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-ыг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10:30 цаг байхаар тогтсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Ж.Баасандоржийг томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар С.Цог, гишүүдээр Т.Бямбасүрэн, Э.Булганчимэг нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Ч.Цогтгэрэл, гишүүдээр Х.Цэцэгмаа, Ж.Азбаяр нарыг тус тус томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийг хуралд танхим болон зайнаас оролцох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Ч.Цогтгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн
202 дугаар хурлын 5 дугаар тогтоолын Хавсралт



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1.	Хурлын ирцийг бүртгэх (Тооллогын комисс)	11:00-11:30
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын комисс)	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хэлэлцүүлэх	80 минут
	1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;	
	2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг батлах тухай;	
	3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;	
	4. 2023 оны ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, үндэслэлийг танилцуулах тухай	
	5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;	
	6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсвийг батлах тухай;	
5.	Асуулт хариулт, санал	30 минут
6.	Санал хураалт	5 минут
7.	Хурлын завсарлага, тооллогын комисс санал хураалтын дүнг гаргах	15 минут
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10.	Хурлыг хаах (Хурлын дарга)	5 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн
202 дугаар хурлын 5 дугаар тогтоолын Хавсралт 2



**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2023 оны жилийн тайлан
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
3. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
4. ТУЗ-ийн Аудитын хорооны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт
5. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин,
6. ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлан
7. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийн төсөл
8. 2023 оны ногдол ашиг хуваарилах эсэх талаарх ТУЗ-ийн тогтоол, үндэслэл
9. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, нэр дэвшигчдийн мэдээлэл



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерын овог нэр

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдолд өгөх санал
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			
2.	Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг батлах тухай;	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай: 1.1. Нийт хөрөнгийг ... төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг ... төгрөгөөр; 1.2. Өр төлбөрийн нийт дүнг ... төгрөгөөр; 1.3. Эзэмшигчийн өмчийг ... төгрөгөөр тус тус баталсугай. 2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.			

3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг баталсугай.			
4.	ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай	1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг Хавсралтаар баталсугай. 2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.			

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг.....	Улсын бүртгэлийн дугаар.....
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал.....
	Гарын үсэг:
Регистрийн дугаар:.....	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг	

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн
202 дугаар хурлын 5 дугаар тогтоолын Хавсралт 3



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерын овог нэр

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
	Ердийн гишүүд	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
	Хараат бус гишүүд	
1		
2		
3		
4		
5		

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг.....	Улсын бүртгэлийн дугаар.....
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал.....
Регистрийн дугаар:.....	Гарын үсэг:
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг	

